

БАТЛАВ

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Д.СҮМЬЯАБАЗАР

2023 оны 09 дүгээр сарын 29

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
АГЕНТЛАГ, ДҮҮРГҮҮДИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДУНД ЯВАГДАХ
“МЭДЬЕ, НЭГДЬЕ” АЯНЫ УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Нийслэл хот үүсэн байгуулагдсаны 384 жилийн ойг угтан Монгол Улсын Засгийн газраас Авлигатай тэмцэх жилийн хүрээнд хэрэгжүүлж буй “5 Ш ажиллагаа”, Авлигаас урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх, нутгийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтнуудын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлийг дэмжих, албан хаагчдын ёс зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдлэг, харилцаа, хандлагыг нэмэгдүүлэх, ур чадварыг сайжруулах, төрийн үйлчилгээг иргэдэд хүнд суртал, чирэгдэлгүй хүргэх байгууллагын үйл ажиллагааны чадавхыг дээшлүүлэхэд энэхүү аяны зорилго оршино.

Хоёр. Аяны хугацаа, хамрах хүрээ

2.1. Аяныг 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс 11 дүгээр сарын 02-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулна.

2.2. Аянд Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлаг, Дүүргийн Засаг даргын Тамгын газрууд хамрагдана.

Гурав. Хэрэгжүүлэх арга хэмжээ

Аяны хүрээнд дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулна. Үүнд:

3.1. Өөрийн байгууллагын үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, брошур зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж олон нийтэд хүргэсэн байх;

3.2. Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх;

3.3. Өөрийн байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг байгууллагуудад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх, сурталчлах арга хэмжээг зохион байгуулах;

3.4. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх гм холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж, үр дүнг тооцсон байх;

3.5. Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах;

3.6. Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах эх үүсвэрийг нэмэгдүүлж, шийдвэрлэлтийн зөрчилгүй, чанар, үр дүнг сайжруулсан байх;

3.7. Байгууллагын төсөв, санхүүгийн сахилга, батыг сайжруулах;

3.8. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангасан байх;

3.9. Байгууллагын албан хаагчдын авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэгийг нэмэгдүүлэх, харилцаа, хандлагыг сайжруулах чиглэлээр сургалт, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан байх;

Дөрөв.Үр дүн

Авлигын эсрэг хууль, тогтоомж, Засгийн газраас хэрэгжүүлж буй 5Ш үйл ажиллагааны хэрэгжилт, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын авлигатай тэмцэх чиглэлээр хийж хэрэгжүүлж буй ажлын үр нөлөө сайжирч, төрийн албан хаагчдын авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, ур чадвар дээшилсэн байна.

Тав. Аяны үр дүнг үнэлэх, урамшуулах

5.1. Байгууллагуудын аяны хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг, нотломжийн хамт 2023 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ.

5.2. Аяны үр дүнг Ажлын хэсэг үнэлэн, агентлагуудаас 1-5 байр, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газраас 1-3 байрыг тус тус шалгаруулан, мөнгөн урамшуулал олгоно.

-----0000-----